

СУМЫН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Увс аймгийн Өмнөговь сум нь 1924 онд байгуулагдсан, хуучнаар Дөрвөд далай хан аймгийн Бишрэлт засгийн хошуу.

Холбоо, Улиаст, Орлого, Баянгол, Намир гэсэн 5 багийн нийт 1068 өрхөд 4320 хүн амьдардаг.

Хүн амын тоогоор Увс аймгийн 19 сумаас эхнээсээ 4-д, газар нутгийн хэмжээгээр 7-д ордог /аймгийн төвийг оролцуулалгүйгээр /хүн амын нягтралаар хамгийн өндөр/1.4 хүн/га/ сум юм.

Газар зүйн байршил

Увс аймгийн баруун өмнө хэсэгт:

- Улаанбаатар хотоос 1516 км,
- Аймгийн төвөөс 119 км зайд байрладаг.

Увс аймгийн Ховд, Тариалан, Наранбулаг, Өлгий, Ховд аймгийн Мянгад, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумтай тус тус хиллэдэг.

Байгаль, газарзүйн онцлог:

Газарзүйн онцлог. Далайн түвшнээс дээш дунджаар 1580 м өргөгдсөн. Газрын гадаргын төрх байдал нь жигд биш, хойд хэсгээрээ уулархаг, өмнөд хэсэг нь тал голдуу, төв хэсгээр өргөн тавиу, тэгш гадарга бүхий уулс хоорондын хөндий, хонхор олонтой нутаг юм.

Газар хөдлөлийн эрчим 5 балл.

Сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ толгод бүхий тал хээр буюу мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиромжтой.

Цаг уурын нөхцөл.

Хуурайдуу сэрүүн зунтай, хахир өвөлтэй.

- 1 дүгээр сарын дундаж температур -23.1°C
- 7 дугаар сарын дундаж температур $+18^{\circ}\text{C}$
- жилийн дундаж салхины хурд 5 м/с
- жилийн хур тундасны нийлбэр 129 мм

Газар нутаг:

Нийт газар нутгийн хэмжээ **314580 га.**

Зориулалт	Хэмжээ /га/	Нийт талбайд эзлэх хувь
Хөдөө аж ахуйн газар	301584.87	95.87
Ойн сан бүхий газар	-	-
Усан сан бүхий газар	7997	2.54
Тусгай хэрэгцээний газар	-	-
Тосгон, суурингийн газар	585.05	0.18
Дэд бүтцийн газар	4413.08	1.41

ЭДИЙН ЗАСАГ


Орон нутгийн төсөв:

Сумын төсвийн нийт орлого нь 456.1 сая төгрөг бөгөөд улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг 411.4 сая төгрөг, сумын өөрийн орлого 44.7 сая төгрөгийн орлогоос бүрддэг.

Орон нутгийн нийт төсвийн зардал нь 434.5 сая төгрөг байна. Нийт зардлын 46.7 хувь нь цалин, 5.2 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл, 11.4 хувийг урсгал шилжүүлэг, 36.7 хувийг нь бусад зардал эзэлж байна.

Эдийн засгийн бүтэц:

Сумын хэмжээнд нийт 28 аж ахуйн нэгж, байгууллага болон ХАА-н үйлдвэрлэлд ажиллагсад болон уул уурхайгаас нийт 4 тэрбум орчим төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, улсад 2.1 сая, аймагт 98.2 сая, орон нутагт 42.0 сая, нийт 142.3 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна.



Сумын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбар тус бүрээр

Хөдөө аж ахуй:

Малын бүтэц

Сумын хэмжээнд 127214 толгой малтайгаас 1029 тэмээ, 2907 адуу, 4086 үхэр, 56807 хонь, 62385 ямаа байна.



Газар тариалан

Сумын хэмжээнд нийт 60.3 га-д газар тариалан эрхэлдэг. Үүнээс 29.8 хувьд нь төмс, хүнсний ногоо, 3.8 хувьд нь жимс, жимсгэнэ, 66.4 хувьд нь тэжээлийн ургамал зэрэг бүтээгдэхүүн тариалж байна.

Инженерийн дэд бүтэц:

Зам тээвэр. Сумын газар нутаг дээгүүр улсын чанартай авто зам дайран өнгөрдөггүй. Багууд хоорондоо шороон замаар холбогддог.

Цахилгаан хангамж. Сумын төв 1995 онд, сумаас 50 км-т орших Улиастай багийн төв 2005 онд тус тус Баруун бүсийн эрчим хүчний системд холбогдсон. Цаашид Баянгол багийг холбохоор Баяннуур сум явах шугамаас 1.8 км агаарын ЦДШ татахаар төсөл тооцоо хийгдсэн. Сумын төвөөс 4.5 км-т 1996 онд баригдсан 110/35/10киловольт/кв/-ийн дэд станцтай.

Ус хангамж. Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн 15 гүний худаг, айл өрх, байгууллага, ААН-ийн ихэнх нь ус түгээх байрнаас усаа авч байна. Усны хатуулаг ихтэй учир гүн өрмийн худгуудад ус цэвэршүүлэх төхөөрөмж тавих шаардлагатай.

Усан сан

- Ашиглагдаж байгаа усан сан байхгүй. Харин нэгдлийн үед бий болгосон усан сангууд устсан.

Ариутгах татуурга. Сумын төвд цэвэрлэх байгууламж, бохир усны худаг, шугам хоолой байхгүй, цаашид төсвийн байгууллагуудыг цэвэр бохир усны системд холбох шаардлагатай.

Цэвэрлэх байгууламж

- Байхгүй

Дулаан хангамж. Сумын төвд төвлөрсөн уурын зуух байхгүй, ЗДТГ, Эрүүл мэндийн төв, Цэцэрлэг, Соёлын төв, Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн харьяа нийт 8 уурын зуух ажиллаж байна.

НИЙГЭМ

Хүн ам:

Хүн ам, өрхийн тоо

Үзүүлэлт	Сумын төвд	Хөдөөд	Нийт
Хүн амын тоо	961	3359	4320
Нийт эрэгтэй			2147
0-4 нас			570
5-9 нас			481
10-14 нас			475
15-18 нас			478
19-24 нас			438
24-29 нас			344
30-34 нас			309
35-39 нас			290
40-44 нас			290
45-49 нас			209
50-54 нас			155
55-59 нас			82
60-65 нас			67
65-аас дээш нас			132
Нийт эмэгтэй			2173
0-4 нас			272
5-9 нас			235
10-14 нас			241
15-18 нас			246
19-24 нас			221
24-29 нас			170
30-34 нас			156
35-39 нас			146
40-44 нас			134
45-49 нас			106
50-54 нас			79
55-59 нас			48
60-65 нас			46
65-аас дээш нас			73
Өрхийн тоо	247	821	1068
Суурин хүн ам			4320
Түр оршин суугч			-

Шилжилт хөдөлгөөн:

Оноор	Шилжиж ирсэн	Шилжиж явсан	Цэвэр шилжилт хөдөлгөөн
2005	24	82	-54
2006	21	89	-68
2007	28	75	-47
2008	26	92	-66
2009	29	73	-44
2010	31	113	-82
2011	51	160	-109
2012	46	122	-76
Бүгд	256	806	-550

Тус суманд 2008-2010 онд тохиолдсон зуд, гамшгийн улмаас шилжин явагсдын тоо нэмэгдсэн боловч өнгөрсөн оноос буурч эхэлж байгаа. Гэхдээ УБ хот болон бусад аймаг, сумаас иргэд шилжин ирж байгаа нь хүн амын тоонд эерэгээр нөлөөлж байна.

Сумын хүн амын 56 хувь нь залуу болон дунд насныхан, 37.5 хувь нь хүүхэд, 6.5 хувь нь хөгшид байна.

Орон сууцны хангамж:

Сумын хэмжээнд инженерийн бүрэн хангамжгүй 36 айлын 3 давхар нэг орон сууц байгаа бөгөөд 1991 онд ашиглалтанд орсон боловч зах зээлийн шуурганд өртөн ихээхэн тоногдож муудсаныг сумын удирдлагын зүгээс холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүсэлт тавьснаар улсын төсвийн 200.0 сая төгрөгөөр 2008-2009 онд засварласан, гэхдээ бүрэн засагдаагүй, засварыг гүйцээхэд ойролцоогоор 300-400 сая төгрөг шаардлагатай гэсэн тооцоо байдаг. Уг орон сууцыг засварлавал төрийн албан хаагчид суух хүсэл их байгаа. 1990-ээд оны эхэн үед баригдсан 24 айлын орон сууцны барилга ашиглагдаж байгаа. Суманд сүүлийн жилүүдэд шинээр инженерийн бүрэн хангамжтай орон сууц баригдаагүй.

Нийгмийн үйлчилгээний барилга, байгууламж

1	Сургууль	хүүхэд	973
2	Сургуулийн дотуур байр	ор	250
3	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	суралцагч	үгүй
4	Цэцэрлэг	хүүхэд	194
5	Эмнэлэг /хэвтэж эмчлүүлэх/	ор	15
6	Спорт заал	тоо	2
7	Биеийн тамирын талбай	м2	7020
8	Соёлын төв	тоо	1
9	Номын сан	Суудал	үгүй
10	Банк	Тоо	2
12	Халуун ус	шүршүүр	1

Боловсрол:

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 34 бүлэгт 928 хүүхэд өдрөөр суралцаж, албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох сургалтанд 45 иргэн суралцаж байна. Бага ангийн хамран сургалт 96.6 хувь, суурь боловсролын хамран сургалт 93.3 хувьд хүрсэн. Ерөнхий боловсролын сургуульд мэргэжилтэй багшийн хангалт 98 хувьтай байгаа ба мэргэжил дээшлүүлэх хөрвөх сургалтанд нийт 2 багш хамрагдаж байна.

Төрийн өмчийн цэцэрлэгийн үндсэн сургалтанд 202, гэр цэцэрлэгт 179, нийт 2-5 насны 466 хүүхэд байна хүүхэд хамрагдаж, сургуулийн өмнөх боловсролын хамралт 71.3 хувьд хүрсэн.

Боловсрол

- Ерөнхий боловсролын 12 жилийн сургууль
- 5-р баг, сумын төвд байршилтай
- 470 хүүхдийн хүчин чадалтай, одоогоор 973 хүүхэд суралцаж байна
- 90 багш, ажиллагсадтай
- 320 хүүхдийн хүчин чадалтай хичээлийн барилга 1984 онд, 150 хүүхдийн хүчин чадалтай өргөтгөлийн барилга 2004 онд тус тус ашиглалтанд орсон, инженерийн бие даасан хангамж байхгүй, тоосгон хийцтэй.
- Хүүхдийн цэцэрлэг
- 5-р баг, сумын төвд байршилтай
- 90 хүүхдийн хүчин чадалтай, одоогоор 202 хүүхэд хүмүүжиж байна
- 21 багш, ажиллагсадтай
- 1984 онд ашиглалтанд орсон тоосгон хийцтэй, зориулалтын барилга. Инженерийн төвлөрсөн хангамжгүй. Ашиглалтанд орсноос хойш их засвар огт хийгдээгүй. Барилгад их засвар зайлшгүй хийх шаардлагатай. 2013 онд 75 хүүхдийн шинэ барилгын ажил эхлэж 80 хувьтай байна.

Эрүүл мэнд

Суманд улсын төсвийн 15 ортой 1 эмнэлэг, 1 эмийн сан үйл ажиллагаа явуулж, 4 их эмч, 17 эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд ажиллаж байна.

2012 онд нийт 129 хүүхэд мэндэлж, 0-1 насны хүүхдийн эндэгдэл 3, эхийн эндэгдэл байхгүй байна. Нийт өвчлөлийг авч үзвэл халдварт бус өвчлөл 1606, осол гэмтэл 36, халдварт өвчлөлийн 18 тохиолдол гарсан байна.

- Эрүүл мэндийн төв
- 5-р баг, сумын төвд байршилтай
- 15 ортой

- 2 их эмч, 8 бага эмч, 4 сувилагч нийт 32 ажиллагсадтай
- 1990 онд ашиглалтанд орсон тоосгон хийцтэй, анх баруун 3 аймгийн эмчилгээ-оношилгооны төв гэсэн статустайгаар баригдсан, зориулалтын барилга. Инженерийн бие даасан хангамжгүй. Эмнэлгийн үйл ажиллагаа явуулах байр хүрэлцээтэй, сум дундын эмнэлгийн статусаар бүрэн ажиллавал уг байранд зайлшгүй их засвар хийх шаардлагатай. Ашиглалтанд орсноос хойш их засвар огт хийгдээгүй.

Соёл, спорт:

2004 онд ашиглалтанд орсон 250 хүний суудалтай Соёлын төвийн тоосгон барилга ашиглагдаж байгаа. Үйл ажиллагаа явуулахад зай багатай, уг нь сургуулийн өргөтгөлийн урлаг заал нэртэйгээр анх баригдсан. Цаашид зориулалтын шинэ байртай болох шаардлагатай.

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 2 спорт зааланд спортын арга хэмжээ зохион байгуулж байна. Уг заалууд сургалтанд зориулагдсан учир талбай багатай, стандартын бус учраас уралдаан тэмцээн явуулахад будилаан маргаан байнга гардаг, үзэгчид багтах боломжгүй. Тиймээс тус суманд орчин үеийн шаардлага хангасан биеийн тамирын заал барих асуудлыг иргэд, хүүхэд залуучууд ихээр тавьж байгаа суманд тулгамдсан асуудлын нэг мөн.

Тус сум Ахуйн үйлчилгээний нэгдсэн төвгүй, 28 жижиг дэлгүүр, нийтийн хоолны 6 цэг, баар 5, үсчин гоо сайхны 1, гутал засварын 1, гар утас засварын 1, оёдлын 1, дугуй засварын 2, ШТС-3, гэрэл зураг, компьютер, каноны үйлчилгээ 2, зочид буудал 2, гэр ахуйн модон эдлэлийн цех 2, төмрийн дархан, гагнуур 3, нийтийн халуун усны 1 цэг, тоглоомын газар 3 салангид үйл ажиллагаа эрхэлж байна.

- Соёлын төв
- 5-р баг, сумын төвд байршилтай
- 250 хүний суудалтай
- 9 ажиллагсадтай
- 2004 онд ашиглалтанд орсон тоосгон хийцтэй, зориулалтын бус барилга. Инженерийн төвлөрсөн хангамжгүй. Тус барилга нь 2004 онд сургуулийн өргөтгөлийн урлагийн заал нэртэйгээр анх баригдсан. Шинээр Соёлын төвийн барилга барих шаардлагатай.

“Дамчойринчиндодьгуулин” хийд

Сумын хэмжээнд 1 сүм хийд байдгаас будда шашны 1 сүм байна.

Тухайн хийдүүдэд нийт 7 хуврага, санваартан ажиллаж байна.

Ажиллах хүч:

Ажиллах хүч салбараар

Салбар	Хэмжих нэгж	2012		
		Сумын төвд	Хөдөөд	Нийт
Аж үйлдвэр	Хүн			
Хөдөө аж ахуй	Хүн	125	1500	1625
Үйлчилгээ	Хүн	280	10	290
Нийт	Хүн	405	1510	1915

Сумын хэмжээгээр нийт 127.2 мянган мал тоологдсоноос эрлийз, нутгийн шилмэл омгийн 55 мянган толгой мал тоологдсон нь нийт малын 43.2 хувь байна.

572 малчин өрх, 400 малтай өрх байгаа нь сумын нийт өрхийн 91 хувийг эзэлж байна.

Сумын хэмжээгээр жилд 2.0 га талбайд төмс, 0.3 га талбайд хүнсний ногоо, 40.0 га талбайд тэжээлийн ургамал тариалж 44.5 тонн төмс, 20.2 тонн хүнсний ногоо, 35.0 тонн тэжээлийн ургамал хураан авч аймгийн хэмжээнд нэлээд хойгуур орж байна.

- Төрийн байгууллагад 190 хүн ажиллаж байна.

Ажилгүйдэл, ядуурал:

Суманд бүртгэлтэй ажилгүй 44 иргэд байна. Нийт ажилгүй иргэдийн 63.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл 18.3 хувийг дээд, 11.3 хувийг тусгай дунд, 45.4 хувийг бүрэн дунд, 16 хувийг бүрэн бус дунд, 9 хувийг бага буюу боловсролгүй хүмүүс тус тус эзэлж байна.

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА

Хот байгуулалт, газрын харилцаа:

Өмнөговь сумын төв нь Засаг захиргаа-хөдөө аж ахуй-үйлчилгээний үүрэг давамгайлсан суурин юм.

Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2008 онд Мерси-Кор Монгол ОУБ-ын төслийн дэмжлэг, санхүүжилтээр орон нутгийн иргэд, байгууллага, ААН-ийн оролцоотойгоор боловсруулсан.

Сумын төвийн суурьшлын бүс хүн амын механик өсөлт/хөдөө багуудын айл өрх газар өмчилж авах болсноор/-өөс шалтгаалан сүүлийн 4 жилийн хугацаанд 100га-аар нэмэгдсэн.

Сумын төвийн нутаг дэвсгэрийн бүсчлэлийн өнөөгийн байдал:

- орон сууц, олон нийтийн бүс 315га
- үйлдвэрлэлийн бүс 11га
- ногоон байгууламж, амралт, аялал жуулчлалын бүс 2.6га
- хөдөө аж ахуйн бүс 1000га
- зуслангийн бүс - га

Өнөөгийн байдлаар 487 иргэн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 37.2га газар өмчилж, 506 иргэн өвөлжөө, хаваржааны зориулалтаар 38.6га газар, газар тариалангийн зориулалтаар 191.1га, худалдаа, үйлчилгээний зориулалтаар 31 иргэн 19.6га газар эзэмшиж байна.

Барилга:

Орон нутгийн барилгын компануудын 2012 оны барилга угсралт, их засварын ажил нь 181 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажил 60 хувийн гүйцэтгэлтэй байна.

Засаг даргын Тамгын газар

- ЗДТГ-ын барилга
- 5-р баг, сумын төвд байршилтай
- 19 ажиллагсадтай
- 1990 онд ашиглалтанд орсон үнсэн блокон хийцтэй, зориулалтын бус барилга. Анх 90 ортой ясли цэцэрлэгийн комбинат нэртэйгээр баригдаж зориулалтаараа 2 жил ашиглагдсан. Инженерийн төвлөрсөн хангамжгүй. Цаашид зориулалтын “Нутгийн удирдлагын ордон” шинээр барих шаардлагатай.

СУМАНД ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСЛҮҮД

- ✓ Малын эрсдэлийн даатгал төсөл
- ✓ Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төсөл
- ✓ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төслүүд
- ✓ Мерси Кор Монгол ОУБ-ын төсөл

СУМЫН БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН

Сумын брэнд бүтээгдэхүүн цагаан ултай гутал

- ✓ Цагаан ултай гутал

СУМЫН ХӨШӨӨ, ДУРСГАЛ

Хөшөө дурсгалын нэр: Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Бугын Дэжидийн цээж хөшөө

Байгуулагдсан он: 2012

Хөшөө, дурсгалын намтар: Б.Дэжидийн мэндэлсний 85 насны ойг тохиолдуулан босгосон. Төр засаг, намын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан, НАХЯ-ны сайд асан, хурандаа генерал

Хөшөө дурсгалын нэр: нутгийн ард Цагааннохой, оросын эрэлхэг хүү Никитин нарын гэгээн дурсгалд зориулсан багана

Хөшөө, дурсгалын намтар: 1921 онд тус сумын нутаг “Арлын хоо” хэмээх газарт болсон цагаантнуудын эсрэг байлдаанд амь эрсэдсэн баатарлаг гавьяаг нь мөнхжүүлэх зорилгоор АХ-ын 90 жилийн ойг тохиолдуулан босгосон.

СУМЫН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ

Тус сум нь *“Хүний хөгжлийн чадавх сайтай, орон нутгийн нөөцөд түшиглэсэн эрчимжсэн хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэр, дэд бүтэц хөгжсөн, аймгийн болон баруун бүсийн эдийн засагт нөлөө бүхий цэцэглэн хөгжиж буй сум болох”* зорилго тавьж дараах гол зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Эдийн засгийн бүтцийг боловсронгуй болгож, хэрэглэгч сумаас үйлдвэрлэгч сум болох суурь нөхцөлийг бүрдүүлэх
- Ажлын байрыг 2.0 дахин нэмэгдүүлж, ажиллах хүчний байршлыг хүн амын суурьшил, газар нутгийн зохион байгуулалт, эдийн засгийн бүтэцтэй уялдуулан зөв байршуулах
- Нийгмийн дэд бүтэц, орон сууцны хангамжийн хувийг дээшлүүлэх
- Баруун 3 аймгийн замын уулзварт оршдог, үүрэн холбооны 4 сүлжээтэй зэрэг давуу талыг түшиглэн баруун 3 аймгийг түшиглэн тоосгоны үйлдвэр байгуулах
- Яврын нүүрс, Сүүжийн давсны, шороон будгийн болон шохойн чулууны ордыг ашиглан үйлдвэр, цех байгуулах
- Сумын эдийн засгийн гол суурь МAA-г хагас эрчимжүүлэх байдлаар хөгжүүлж нэгж малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх
- Угсаатны өвөрмөц соёл, зан заншил, байгалийн үзэсгэлэнт болон түүх, соёлын дурсгалт газруудыг түшиглэн амралт сувилал, аялал жуулчлал хөгжүүлэх
- Сумын иргэд, байгууллага, ААН-ийг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах үнээний ферм байгуулах ажлыг дэмжих/нэгдлийн үед ферм ажиллуулж байсан туршлагатай/
- Ховдын гол, Орлогын голын төгсгөлийн үржил шимт хөрсөнд төмс, хүнсний ногоо ихээр тариалах
- Хүн ам ихтэй төвлөрсөн суурин болж байгаатай уялдуулан төв гудамжаар хатуу хучилттай зам тавих